



ЗАВХАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Завхан аймгийн Боловсролын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ЗАА-2025/116/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Улиастай сум

2025 он

Завхан аймаг дахь Төрийн Аудитын газрын
тэргүүлэх аудитор: Д.Бат-Ундраа

Утас: 99993365

Цахим хаяг: Bat-Undraad@audit.gov.mn

Аудитын менежер: Х.Болдбаатар

Утас: 99105506

Цахим хаяг: Boldbaatar.kh@audit.gov.mn

Аудитор: Д.Пүүжмаа

Утас: 99080797

Цахим хаяг: puujmaad@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
 - 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа
 - 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин
 - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал
 - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт
4. Аудитын тайлан

 - 4.1 Ерөнхий зүйл
 - 4.2 Материаллаг байдал
 - 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....
 - 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
 - 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
 - 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

5. Аудитын илрүүлэлт
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл.....

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ЗДТГ	Засаг Даргын Тамгын Газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал



**ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

81090 Улаангай, Завхан аймаг
Утас/Факс: 7046-36-12
И-мэйл: zavkhan@audit.gov.mn

БОЛОВСРОЛЫН ГАЗРЫН
ДАРГА Д.БЯМБАЦОГТ-Д

2025.02.22 № 253
танай _____ -ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Боловсролын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Боловсролын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Боловсролын газар нь 59.8 сая төгрөгийн үндсэн хөрөнгө хандив тусламжаар ирснийг данс бүртгэлд тусгаж, 19.1 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг акталж, данс бүртгэлээс хассан байна.

Аудитын гол асуудал

Боловсролын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлийг шалгахад, цалинг зөрүүтэй тооцоолсон, бараа материалын тайланг буруу гаргасан, бараа материалын тооллого хийгээгүй зөрчил илэрсэн байна.

Бусад асуудлын хэсэг

2022 онд Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар барьж ашиглалтад оруулсан барилгын үнийг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газраас тайлант онд 467.1 сая төгрөгөөр нэмэгдүүлж бүртгэх 583 дугаар тогтоолын дагуу барилга байгууламжийн үнийг нэмэгдүүлэн данс бүртгэлд тусгасан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

D:/disk/Албан бичиг/Дүгнэлт

8105 2454

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Д.БАТ-УНДРАА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>89,977,923.50</u>	<u>90,522,923.50</u>
335	Бусад авлага	300,000.00	-
33510	Байгууллагаас авах авлага	300,000.00	-
35	БАРАА МАТЕРИАЛ	89,677,923.50	90,522,923.50
351	Түүхий эд материал	61,133,816.00	61,133,816.00
35110	Тусгай зориулалттай материал	61,133,816.00	61,133,816.00
35300	Бэлэн бүтээгдэхүүн	920,000.00	920,000.00
354	Хангамжийн материал	27,624,107.50	28,469,107.50
35410	Бичиг хэргийн материал	25,000.00	570,000.00
35420	Аж ахуйн материал	12,624,470.00	12,624,470.00
35430	Сэлбэг хэрэгсэл	35,000.00	35,000.00
35470	Бусад хангамжийн материал	14,939,637.50	15,239,637.50
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1,797,871,737.56</u>	<u>2,260,052,736.63</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,797,871,737.56	2,260,052,736.63
39100	Газар		
392	Биет хөрөнгө	1,794,531,737.56	2,256,712,736.63
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,713,714,457.00	2,161,711,466.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(30,372,000.40)	(45,968,853.94)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	33,600,000.00	33,600,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(11,200,000.00)	(14,560,000.00)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	205,737,690.40	265,489,565.4
39206	Хуримтлагдсан элэгдэл	(135,824,486.27)	(164,034,738.03)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	44,759,609.00	50,501,609.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(32,641,865.53)	(35,538,811.83)
39214	Бусад үндсэн хөрөнгө	10,000,000.00	10,250,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(3,341,666.64)	(4,837,499.97)
39217	Ном	100,000.00	100,000.00
393	Биет бус хөрөнгө	3,340,000.00	3,340,000.00
39301	Программ хангамж	1,150,000.00	1,150,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,150,000.00)	(1,150,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	3,340,000.00	3,340,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>1,887,849,661.06</u>	<u>2,350,575,660.13</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>14,511,857.12</u>	
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	14,511,857.12	-
413	Өглөг	14,511,857.12	-
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	14,511,857.12	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>1,873,337,803.94</u>	<u>2,350,575,660.13</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	1,873,337,803.94	2,350,575,660.13
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	240,015,492.00	240,015,492.00
51101	Өмч: - төрийн	240,015,492.00	240,015,492.00

512	Хуримтлагдсан үр дүн	1,626,909,485.88	2,104,147,342.07
51210	Өмнөх үеийн үр дүн	(39,806,850.08)	1,626,909,485.88
51220	Тайлант үеийн үр дүн	1,666,716,335.96	477,237,856.19
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	6,412,826.06	6,412,826.06
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>1,887,849,661.06</u>	<u>2,350,575,660.13</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	6,132,061,251.57	9,052,595,350.00
120	Нийтлэг татварын бус орлого	1,941,624,347.33	526,837,915.00
120009	Бусад орлого	10,000.00	-
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	1,694,640,057.00	526,837,915.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	246,974,290.33	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	4,190,436,904.24	8,525,757,435.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	3,954,481,600.00	7,388,741,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	3,954,481,600.00	7,388,741,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	235,955,304.24	1,137,016,035.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	23,546,406.24	-
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	146,397,000.00	1,100,075,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	64,631,298.00	35,702,925.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,380,600.00	1,238,110.00
134003	Нийгмийн даатгалын сангаас эмнэлгүүдэд олгох санхүүжилт		
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	4,219,232,225.28	8,575,357,493.81
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,219,232,225.28	8,575,357,493.81
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,012,726,535.20	1,540,034,083.38
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	530,527,799.88	784,463,461.14
210101	Үндсэн цалин	301,830,435.66	451,817,131.28
210102	Нэмэгдэл	125,656,617.89	210,804,612.86
210103	Унаа хоолны хөнгөлөлт	66,690,600.00	64,720,000.00
210104	Урамшуулал	24,212,577.12	57,121,717.00
210105	Гэрээт ажлын хөлс	12,137,569.21	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	78,969,471.95	94,560,219.74
210201	Тэтгэврийн даатгал	58,877,900.13	63,270,774.44
210202	Тэтгэмжийн даатгал	5,022,895.14	7,822,360.71
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,018,290.65	3,911,180.81
210204	Ажилгүйдлийн даатгал	1,004,594.90	3,911,180.54
210205	Эрүүл мэндийн даатгал	10,045,791.13	15,644,723.24
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	60,719,999.92	74,002,251.57

210301	Гэрэл, цахилгаан	3,079,741.92	3,142,200.62
210302	Түлш, халаалт	54,612,000.00	64,312,850.95
210303	Цэвэр, бохир ус	3,028,258.00	6,547,200.00
2104	Хангамж, бараа материалын зардал	13,675,200.01	18,525,460.00
210401	Бичиг хэрэг	3,898,000.00	941,050.00
210402	Тээвэр, шатахуун	3,029,300.01	7,961,700.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	292,710.00	279,080.00
210404	Ном, хэвлэл	7,500.00	46,970.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	628,000.00	605,100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,819,690.00	8,691,560.00
2107	Томилолт, зочны зардал	2,369,800.00	3,365,600.00
210702	Дотоод албан томилолт	2,369,800.00	3,365,600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,210,298.00	155,272,250.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,210,298.00	155,272,250.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	321,253,965.44	409,844,840.93
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,558,350.00	4,223,700.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	279,799,488.00	336,372,225.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	36,896,127.44	69,248,915.93
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,206,505,690.08	7,035,323,410.43
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,183,542,948.00	6,988,100,770.81
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	1,605,696,016.00	1,501,855,519.61
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	1,574,169,932.00	4,685,545,251.20
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,677,000.00	800,700,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	22,962,742.08	47,222,639.62
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	16,450,025.84	43,455,929.62
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	6,512,716.24	3,766,710.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>1,912,829,026.29</u>	<u>477,237,856.19</u>
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	246,112,690.33	-
225002	Найдваргүй авлагын алдагдал	58,400.00	-
225011	Үнэ төлбөргүй гарсан зардал - Бараа материал	246,054,290.33	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(246,112,690.33)	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>1,666,716,335.96</u>	<u>477,237,856.19</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>4,190,446,904.24</u>	<u>8,525,757,435.00</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	10,000.00	-
120	Нийтлэг татварын бус орлого	10,000.00	-
120009	Бусад орлого	10,000.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	4,190,436,904.24	8,525,757,435.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	3,954,481,600.00	7,388,741,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	3,954,481,600.00	7,388,741,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	235,955,304.24	1,137,016,035.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	23,546,406.24	-
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	146,397,000.00	1,100,075,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	64,631,298.00	35,702,925.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,380,600.00	1,238,110.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>4,168,847,004.24</u>	<u>8,521,165,435.00</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,168,847,004.24	8,521,165,435.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	962,341,314.16	1,485,842,024.57
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	517,289,006.29	796,170,638.00
210101	Үндсэн цалин	251,168,849.66	435,692,951.90
210102	Нэмэгдэл	151,239,740.87	238,290,100.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	66,690,600.00	64,315,869.10
210104	Урамшуулал	37,742,040.62	57,871,717.00
210105	Гэрээт ажлын хөлс	10,447,775.14	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	78,969,471.95	97,364,900.00
210201	Тэтгэврийн даатгал	58,877,899.21	67,768,100.00
210202	Тэтгэмжийн даатгал	5,022,895.14	7,399,200.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,018,290.92	3,699,600.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,004,595.22	3,699,600.00
210205	Эрүүл мэндийн даатгал	10,045,791.46	14,798,400.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	60,719,999.92	74,002,251.57

210301	Гэрэл, цахилгаан	3,079,741.92	3,142,200.62
210302	Түлш, халаалт	54,612,000.00	64,312,850.95
210303	Цэвэр, бохир ус	3,028,258.00	6,547,200.00
2104	Хангамж, бараа материалын зардал	13,256,400.00	19,070,460.00
210401	Бичиг хэрэг	3,274,500.00	1,486,050.00
210402	Тээвэр, шатахуун	3,038,700.00	7,961,700.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	292,710.00	279,080.00
210404	Ном, хэвлэл	7,500.00	46,970.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	628,000.00	605,100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,014,990.00	8,691,560.00
2107	Томилолт, зочны зардал	2,369,800.00	3,365,600.00
210702	Дотоод албан томилолт	2,369,800.00	3,365,600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,378,798.00	155,272,250.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,378,798.00	155,272,250.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	284,357,838.00	340,595,925.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,558,350.00	4,223,700.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	279,799,488.00	336,372,225.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,206,505,690.08	7,035,323,410.43
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,183,542,948.00	6,988,100,770.81
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	1,605,696,016.00	1,501,855,519.61
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	1,574,169,932.00	4,685,545,251.20
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,677,000.00	800,700,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	22,962,742.08	47,222,639.62
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	16,450,025.84	43,455,929.62
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	6,512,716.24	3,766,710.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>21,599,900.00</u>	<u>4,592,000.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	21,599,900.00	4,592,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	21,599,900.00	4,592,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	21,599,900.00	4,592,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	21,599,900.00	4,592,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(21,599,900.00)</u>	<u>(4,592,000.00)</u>

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2016 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	240,015,492.00	6,412,826.06	-39,806,850.08	206,621,467.98
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	240,015,492.00	6,412,826.06	-39,806,850.08	206,621,467.98
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	0.00	0.00	0.00	0.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	0.00	0.00	0.00	0.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
C07	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	1,666,716,335.96	1,666,716,335.96
C08	2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	240,015,492.00	6,412,826.06	1,626,909,485.88	1,873,337,803.94
D01	2017 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	240,015,492.00	6,412,826.06	1,626,909,485.88	1,873,337,803.94
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	240,015,492.00	6,412,826.06	1,626,909,485.88	1,873,337,803.94
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				0.00
D08	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	477,237,856.19	477,237,856.19
D09	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	240,015,492.00	6,412,826.06	2,104,147,342.07	2,350,575,660.13

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,954,481,600.00	3,938,041,574.16	7,388,741,400.00	7,345,285,470.38
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,954,481,600.00	3,938,041,574.16	7,388,741,400.00	7,345,285,470.38
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	758,562,600.00	757,395,626.16	1,160,383,400.00	1,157,184,699.57
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	517,930,400.00	517,289,006.29	797,225,100.00	796,170,638.00
210101	Үндсэн цалин	280,275,200.00	251,168,849.66	470,017,800.00	435,692,951.90
210102	Нэмэгдэл	151,959,700.00	151,239,740.87	238,290,100.00	238,290,100.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	31,944,000.00	66,690,600.00	31,337,100.00	64,315,869.10
210104	Урамшуулал	53,751,500.00	37,742,040.62	57,580,100.00	57,871,717.00
210105	Гэрээт ажлын хөлс	-	10,447,775.14	-	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	78,969,500.00	78,969,471.95	97,364,900.00	97,364,900.00
210201	Тэтгэврийн даатгал	58,877,900.00	58,877,899.21	67,768,100.00	67,768,100.00
210202	Тэтгэмжийн даатгал	5,022,900.00	5,022,895.14	7,399,200.00	7,399,200.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,018,300.00	4,018,290.92	3,699,600.00	3,699,600.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,004,600.00	1,004,595.22	3,699,600.00	3,699,600.00
210205	Эрүүл мэндийн даатгал	10,045,800.00	10,045,791.46	14,798,400.00	14,798,400.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	60,720,000.00	60,719,999.92	76,128,400.00	74,002,251.57
210301	Гэрэл, цахилгаан	5,760,000.00	3,079,741.92	5,650,600.00	3,142,200.62
210302	Түлц, халаалт	51,840,000.00	54,612,000.00	64,313,000.00	64,312,850.95
210303	Цэвэр, бохир ус	3,120,000.00	3,028,258.00	6,164,800.00	6,547,200.00
210304	Байрны түрээс				
2104	Хангамж, бараа материалын зардал	14,856,300.00	14,856,300.00	17,846,200.00	17,832,460.00
210401	Бичиг хэрэг	2,928,700.00	3,274,500.00	1,107,300.00	1,486,050.00
210402	Тээвэр, шатахуун	2,980,300.00	3,038,700.00	7,961,700.00	7,961,700.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	204,000.00	292,710.00	200,100.00	279,080.00
210404	Ном, хэвлэл	127,900.00	107,500.00	71,500.00	46,970.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	606,400.00	628,000.00	648,800.00	605,100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	8,009,000.00	7,514,890.00	7,856,800.00	7,453,560.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	20,000,000.00	20,000,000.00	-	-
210601	Багаж, техник, хэрэгсэл	20,000,000.00	20,000,000.00	-	-
2107	Томиллолт, зочны зардал	2,372,700.00	2,369,800.00	3,365,600.00	3,365,600.00
210702	Дотоод албан томиллолт	2,372,700.00	2,369,800.00	3,365,600.00	3,365,600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	5,378,800.00	5,378,798.00	155,276,600.00	155,272,250.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,378,800.00	5,378,798.00	155,276,600.00	155,272,250.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	58,334,900.00	57,812,250.00	13,176,600.00	13,176,600.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,560,300.00	4,558,350.00	4,473,700.00	4,473,700.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	53,774,600.00	53,253,900.00	8,702,900.00	8,702,900.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,195,919,000.00	3,180,645,948.00	6,228,358,000.00	6,188,100,770.81
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,195,919,000.00	3,180,645,948.00	6,228,358,000.00	6,188,100,770.81
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	1,619,902,200.00	1,605,696,016.00	1,535,443,400.00	1,501,855,519.61
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	1,575,232,600.00	1,574,169,932.00	4,692,145,300.00	4,685,545,251.20
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	784,200.00	780,000.00	769,300.00	700,000.00
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	-	-	26	-
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	-	-	1	1
610001	Төсвийн байгууллага				
610002	Төсвөөс гадуур байгууллага				
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	-	-	26	26
620001	Удирдах ажилтан	-	-	1	1
620002	Гүйцэтгэх ажилтан	-	-	22	22
620003	Үйлчлэх ажилтан	-	-	3	3

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,137,016,035.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,137,016,035.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	333,249,325.00
2104	Хангамж, бараа материалын зардал	1,238,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,238,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	332,011,325.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	332,011,325.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	803,766,710.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	800,000,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	800,000,000.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	3,766,710.00
213303	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	3,766,710.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,137,016,035.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,137,016,035.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,100,075,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	35,702,925.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,238,110.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Завхан аймгийн Боловсролын газар нь Боловсролын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 281-д заасан бүрэн эрхийн хүрээнд үйл ажиллагаа явуулж буй Боловсрол шинжлэх ухааны яамны харьяа байгууллага юм.

2024 онд Боловсролын газраас 5 зорилтын хүрээнд 84 арга хэмжээг төлөвлөснөөс, гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг 84.8 хувиар дүгнүүлжээ.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Боловсролын газар нь үйл ажиллагаандаа Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай, Төсвийн тухай, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Төрийн албаны тухай, Хөдөлмөрийн тухай, Шилэн дансны тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай зэрэг хуулиудыг голлон мөрдөж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлээр дараах хууль, журамд өөрчлөлт орсон байна.

- Засгийн газрын 2024 оны 128 дугаар тогтоол “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай”
- Засгийн газрын 2024 оны 104 дүрээр тогтоол “Төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн боловсролын сургууль, политехник коллежийн багш, ажилтанд мөнгөн тэтгэмж олгох журам”
- Засгийн газрын 2024 оны 84 дүгээр тогтоол “Төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэл, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн тогтоох тухай”
- Засгийн газрын 2024 оны 82 дугаар тогтоол “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид орон нутагт ажилласны нэмэгдэл олгох журам”

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Боловсролын газрын 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг *аккруэл* сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Боловсролын газрын 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 462.8 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	300.0	0	-300.0
Бараа материал	88,677.9	90,522.9	845.0
Үндсэн хөрөнгө	1,797,871.7	2,260,052.7	462.181.0
Нийт хөрөнгө	1,887,849.6	2,350,575.6	462.726.0
Өр төлбөр	14,511.9	0	-14,511.9
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1.873.337.8	2,350,575.6	477.237.8
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,887,849.6	2,350,575.6	462.726.0

Дээрх хүснэгтээс харахад дараах данснуудад нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 462.2 сая төгрөгөөр өссөн нь 2022 онд Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар барьж ашиглалтад оруулсан барилгын үнийг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газраас тайлант онд 467.1 сая төгрөгөөр нэмэгдүүлж бүртгэх 583-р тогтоолын дагуу барилга байгууламжийн үнийг нэмэгдүүлэн данс бүртгэлд тусгаснаас шалтгаалж өссөн байна.

Өглөг дансны үлдэгдэл 14.5 сая төгрөгөөр буурсан байгаа нь өмнөх оны ХХОАТ-ын өглөгийг барагдуулсан ажиллажээ.

Засгийн газрын дансны үлдэгдэл 2,350.5 сая төгрөг болж 477.2 сая төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг Улсын төсвөөс 7,221.9 сая , нийт зарлагыг 7,221.9 сая сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийг батлахдаа өмнөх оны гүйцэтгэлд үндэслэн, 398.4 сая төгрөгөөр өсгөн 7,388.7 сая төгрөгөөр баталжээ.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх сургуулийн өмнөх боловсрол, ерөнхий боловсрол, боловсрол шинжлэх ухааны бодлого гэсэн 3 хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхээр 7,388.7 сая төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр баталсан байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 7,345.5 сая төгрөгийн санхүүжилт олгож, гүйцэтгэл 99.4 хувьтай байна.

Тайланд онд 7,345.5 сая төгрөгийн зардал санхүүжүүлж, 43.4 сая төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	71808-Боловсрол, шинжлэх ухааны бодлого удирдлага	1,269,793.3	1,266,325.0	3,268.0	
2	71801-Сургуулийн өмнөх боловсрол	1,873,704.4	1,865,104.3	8,600.1	
3	71802- Ерөнхий боловсрол	4,245,243.7	4,213,656.7	31,587.0	
	Нийт дүн	7,388,741.7	7,345,086.3	43,455.1	

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт санхүүжилтээр 1.199.0 сая төгрөгийн орлого бүрдүүлсэн байна. Үүнд:

- ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан 1,160.1 сая төгрөг нь олимпиад,чадварлаг багш хөтөлбөр, багш нарт олгосон орон сууцны дэмжлэгийн санхүүжилт
- Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан 35.7 сая төгрөг нь үндсэн сургалт, томиллолт болон бусад зардлын санхүүжилт
- Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого төвлөрүүлсэн 3.2 сая төгрөг нь байрны түрээсийн орлогоос тус тус бүрдүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Орон нутагт хэрэгжүүлж буй “Чадварлаг багш” хөтөлбөрийн хамтрагч байгууллагаар ажилласан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Боловсролын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Д.Пүүжмаа гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Болдбаатар, дарга тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа нар тус тус хэрэгжүүлсэн.

Боловсролын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Завхан аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 01/43 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг Дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 8,575.3 сая төгрөгийн 1.5 хувь буюу 128.6 сая төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотой төсвийг хэмнэх талаар арга хэмжээ авч ажилласныг шалгахад хууль зөрчсөн алдаа илрээгүй.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор

www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны хэрэгжилтийг шалгахад тайлант хугацаанд оруулах ёстой мэдээллийг бүрэн байршуулсан байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Бусад хууль тогтоомжтой холбоотой алдаа зөрчил илрээгүй.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Боловсролын газрын 2024 оны санхүүгийн тайланд завсрын аудитыг хийгээгүй.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар нийт 352.4 сая сая төгрөгийн зөрчил илэрсний 32.6 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 300.0 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага, 19.8 сая төгрөгийн зөрчилд 3 заалт зөвлөмж хүргүүлжээ..

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	6	32,633.9	6	32,633.9	100
Албан шаардлага	11	300,048.9	11	268,803.5	95.9
Зөвлөмж	3	19,798.5	3	19,798.5	95.0
Нийт дүн	20	352,481.3	20	321,235.9	96.9

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар залруулах алдаа илрээгүй.

Аудитаар нийт 105.0 сая төгрөгийн зөрчил¹ илэрснээс, 102.2 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, 2.8 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоолоо.

5.1 Төлбөрийн акт

Илрүүлэлт: Цалинг 1.0 сая төгрөгөөр зөрүүтэй тооцон олгосон, замын зардлыг 0.5 сая төгрөгөөр илүү тооцоолон олгосон, төсвийн мэргэжилтэнд 1.3 сая төгрөгийн балансын урамшууллыг дээд газрын шийдвэргүй олгосон нь:

Төсвийн тухай хуулийн 16.5.3 “батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох”, 16.5.5 “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, 41.2.2-д “батлагдсан төсвийн

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

хүрээнд зарлага гаргах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2 "Нягтлан бодох бүртгэлийн ажилд үр бүтээл гарган ажилласан нягтлан бодох бүртгэлийн ажилтныг шагнаж урамшуулж болно" гэж заасантай нийцэхгүй байна.

5.2 Албан шаардлага

Илрүүлэлт: Аймгийн Засаг даргын захирамжаар баталсан "Чадварлаг багш" хөтөлбөрийн хүрээнд 11.7 сая төгрөгөөр БНСУ-д туршлага судалсан мэргэжилтнүүдээс, туршлага судалсан болон орон нутагтаа хийж хэрэгжүүлсэн ажлын тайлан авч биелэлтийг тооцоогүй

Бараа материалын тайланг үнэн зөв гаргаагүй, бараа материалын тооллого хийж ирүүлээгүй 90.5 сая төгрөгийн алдаа илэрсэн зэрэг нь:

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах, 16.5.5."батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 41.2.2."батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах",

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1."Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккруэль сууриар хөтөлнө", 12 дугаар зүйлийн 12.2."Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ", 12.2.1."жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө", гэж заасныг тус тус зөрчсөн байна

5.3 Зөвлөмж

Аудитаар зөвлөмж өгөгдөөгүй

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллага д шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Цалинг зөрүүтэй тооцон олгосон	1	961.4	1	961.4								
Мэргэжилтнүүдэд замын зардал давхардуулан олгосон	1	567.8	1	567.8								
2023 оны санхүүгийн тайлан баталгаажуулах аудитаар "Сөрөг" санал дүгнэлт авсан байхад төсөв төрийн сангийн мэргэжилтэндээ балансын урамшуулал олгосон	1	1,300.0	1	1,300.0								
Аймгийн Засаг даргын захирамжаар баталсан "Чадварлаг багш" хөтөлбөрийн хүрээнд БНСУ-д туршлага судалсан мэргэжилтнүүдээс туршлага судалсан болон орон нутагтаа хийж хэрэгжүүлсэн ажлын тайлан авч биелэлтийг тооцоогүй	1	11,700.0			1	11,700.0						
Бараа материалын тайланг үнэн зөв гаргаагүй	1	0			1	0						
Бараа материалын жилийн эцсийн тооллого зохион байгуулаагүй	1	90,522.9			1	90,522.9						
Дүн	6	105,052.1	3	2,829.2	3	102,222.9						

БОЛОВСРУУЛСАН : АУДИТОР

ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Д.ПҮҮЖМАА 2025.02.24

Х.БОЛДБААТАР 2025.02.24

Д.БАТ-УНДРАА 2025.02.24